



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БАЯРСАЙХАН ТАНАА

2017.02.17 № 3/210
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу БСШУСЯ-ны аппаратын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

БСШУСЯ-ны аппарат нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

БСШУСЯ-ны аппаратын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЭНХЗАЯА

САА0122



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМНЫ АППАРАТЫН ТӨСВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу.**

Үндэсний аудитын газрын
Санхүүгийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: С.Энхзаяа
Утас:261628
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Болд
Утас:261628
Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Цэрэнхүү
Утас:261628
Цахим хаяг:
Tserenkhuu_audit@gov.mn

Үндэсний аудитын газрын хаяг:
Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар-15160,
Монгол Улс

Цахим хуудас: audit.mn

2016 оны 2 дугаар сар

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд БСШУСЯ-ны аппаратын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/265/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

БСШУСЯ-ны аппаратын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

БСШУСЯ-ны аппаратын төсвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дугаар сарын 10-ныг хүртэл хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Цэрэнхүү, аудитор Р.Цолмон, П.Цэнгүүн нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

БСШУСЯ-ны аппаратын төсвийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 01 дүгээр сарын 25-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар санхүүгийн тайлангийн аудитыг 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд БСШУСЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

БСШУСЯ-ны аппаратын төсвийн захирагч нь Монгол улсын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай, Спортын тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай зэрэг хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг Төсвийн тухай хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол улсын Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг тусгасан байна.

БСШУСЯ-ны эрхэм зорилго нь иргэн бүрийг бие даан сурах, ажиллах чадвартай болгон төлөвшүүлэх, “Зөв монгол хүн”-ийг хөгжүүлэх олон талт нөхцөл боломжийг бүрдүүлэх, эрдэм шинжилгээний ажлын чанар, үр өгөөжийг сайжруулан, судалгаа инновацийн үйл ажиллагааг эрчимжүүлж, эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд оршиж байна.

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл нь ерөнхий боловсролын сургалтад хүүхэд бүрийг хөгжүүлэх, багш бэлтгэх тогтолцооны шинэчлэл хийх, боловсролын чанар, хүртээмж, өрсөлдөх чадварыг сайжруулах, насан туршийн боловсролын тогтолцоог бүрдүүлэх, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, боловсрол шинжлэх ухааны салбарын эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын бодлогыг шинэчлэхээр ажиллаж ирсэн байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дүгээр зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу БСШУСЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

БСШУСЯ-ны аппаратын 2016 оны төсвийг Сангийн яамны яамны Төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

БСШУСЯ-ны аппаратын үйл ажиллагааны талаар /ТАБ-СТА-А1/ маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар БСШУСЯ-ны аппаратын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

БСШУСЯ-ны аппаратын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн материаллаг байдлын үнэлгээг нийт зардлын 2% буюу 468.8 сая төгрөгөөр тогтоов.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад төсвийн шууд захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. Олон улсын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн програм уялдсан байна.

Төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

БСШУСЯ-ны аппарат нь нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм ашиглан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

БСШУСЯ-ны аппаратын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Сангийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс урсгал зардалд 22,002.0 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд 21,287.1 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 714.9 сая төгрөгөөр хэмнэсэн ба үйл ажиллагаанаас 90.0 сая төгрөгийн орлого олсон байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын 3, нарийвчилсан 3, нийт 6 горим, сорил гүйцэтгэв. Аудитын явцад дараах гол эрсдэлүүдийг олж тогтоов. Үүнд:

- Батлагдсан төсөвт зардлыг хэтрүүлсэн байх
- Хэрэгцээ шаардлага хангахгүй үндсэн хөрөнгө, тавилга эд хогшил, бараа материал байх /эвдэрсэн, элэгдэлд орсон, чанаргүй, хоцрогдсон, хугацаа хэтэрсэн/
- Санхүүгийн тайланд авлага, өр төлбөрийг тусгаагүй, зөрүүтэй тусгагдсан байх, авлага, өр төлбөр нэмэгдсэн байх
- Авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байх
- Хөрөнгө, зардал буруу ангилагдан бүртгэгдсэн байх
- Холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх, тушаал буруу гарсан байх
- Бараа материал өөрийн эзэмшилд байхгүй байх

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

БСШУСЯ-ны аппаратын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

1. Батлагдсан төсвийг нийт дүнгээр хэмнэсэн боловч бичиг хэргийн зардлыг 1.6 сая, шуудан холбооны зардлыг 1.4 сая, хангамжийн материал, аж ахуйн эд хогшил авах зардлыг 0.3 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулахгүй байх, төсвийн төлөвлөлтийг үндэслэлтэй боловсруулах талаар аудитын зөвлөмж өгөх,

2. Бараа материалын жилийн эцсийн тооллогын бүртгэлээс зарим бараа материал бодитой оршин байгаа эсэхийг түүвэрлэн шалгахад 80,0 мянган төгрөгийн үнэтэй "Чингис хааны өв" ном 349 ширхэг байхгүй байгаа нь санхүүгийн тайланд "оршин байх", санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө, өр төлбөр тухайн байгууллагад бодитой оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайлангийн дээрх батламж, мэдэгдлийг ханган, Төв түүхийн музейтэй уг номын талаар тооцоо нийлж, шилжүүлэх эсэх тухай асуудлыг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлэх талаар аудитын зөвлөмж өгөх,

3. Яамны төсөл, арга хэмжээний зардлын гүйцэтгэлийг түүвэрлэн шалгахад зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэл гарсан боловч санхүүжилтийн эрх нээгдээгүйгээс өр, авлага үүссэн байна. Тухайлбал: Архангай аймгийн Заяын хүрээний сүмийн барилгын ажлыг "Сүлд уул" ХХК гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгч, тайлант оны эцэст 132.9 сая төгрөгийн авлагатай гэж тус яамтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан ч санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтлөнө", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг мөрдөж ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх

4. Яамны аппаратын тайлант оны өглөгийн үлдэгдэл өнгөрсөн оноос 141,852.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн, үүнээс нэр бүхий 4 газартай 4,891.4 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэж заасныг мөрдөж ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулах материаллаг бус алдаа тогтоогдоогүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төсвийн шууд захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг бус 310.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд холбогдох зөвлөмжийг өгч ажиллаа.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

БСШУСЯ-ны аппаратын 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас аудит хийж "Зөрчилгүй" дүгнэлт өгсөн бөгөөд аудитаар өгөгдсөн 4 зөвлөмжийг бүрэн биелүүлж ажилласан байна.

Зөвлөмж:

БСШУСЯ-ны аппаратын удирдлагад өгөх 4 зөвлөмжийг менежментийн захидалд дэлгэрэнгүй харуулсан.

Зөрчилгүй санал дүгнэлт

БСШУСЯ-ны аппаратын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМНЫ АППАРАТЫН ТӨСВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1	
Зардал	6

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 2	
Бараа материал	6

Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс:

Асуудал 3	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6

Тэргүүлэх ач холбогдол №4 зүйлс:

Асуудал 4	
Өр төлбөр	7

2010 оны 3 дугаар сарын
01

2016 оны 02 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг БСШУСЯ-ны аппаратын төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг Төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний нягтлан бодох бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан БСШУСЯ-ны удирдлага, санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

Батлагдсан төсвийг нийт дүнгээр хэмнэсэн боловч бичиг хэргийн зардлыг 1.6 сая, шуудан холбооны зардлыг 1.4 сая, хангамжийн материал, аж ахуйн эд хогшил авах зардлыг 0.3 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

Эрсдэлүүд

Төсөв хэтрэх, төсвийг үр ашиггүй зарцуулах, холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчигдөх

ҮАГ-ын зөвлөмж

Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах, төсөв хэтрүүлэхгүй байх, төсвийн төлөвлөлтийг үндэслэлтэй боловсруулах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ҮАГ-ын ажиглалт

Бараа материалын жилийн эцсийн тооллогын бүртгэлээс зарим бараа материал бодитойгоор оршин байгаа эсэхэд түүвэр хийж, шалгаж үзэхэд 80,0 мянган төгрөгийн үнэтэй "Чингис хааны өв" ном 349 ширхэг байхгүй байгаа нь" санхүүгийн тайланд "оршин байх", "санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө, өр төлбөр тухайн байгууллагад бодитой оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эрсдэлүүд

Дотоод хяналтын тогтолцоо сулрах, санхүүгийн тайлангийн батламж, мэдэгдэл зөрчигдөх

ҮАГ-ын зөвлөмж

Санхүүгийн тайлангийн дээрх батламж, мэдэгдлийг ханган, Төв түүхийн музейтэй уг номын талаар тооцоо нийлж, шилжүүлэх эсэх тухай асуудлыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ҮАГ-ын ажиглалт

Яамны төсөл, арга хэмжээний зардлын гүйцэтгэлийг түүвэрлэн шалгахад зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэл гарсан боловч санхүүжилтийн эрх нээгдээгүйгээс өр, авлага үүссэн байна. Тухайлбал: Архангай аймгийн Заяын хүрээний сүмийн барилгын ажлыг "Сүлд уул" ХХК гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгч, тайлант оны эцэст 132.9 сая төгрөгийн авлагатай гэж тус яамтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан ч санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтлөнө”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэж заасныг мөрдөж ажиллах

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд авлага, өр төлбөр тусгагдаагүй байх, авлага, өр төлбөрийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ҮАГ-ын ажиглалт

Яамны аппаратын тайлант оны өглөгийн үлдэгдэл өнгөрсөн оноос 141,852.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн, үүнээс нэр бүхий 4 газартай 4,891.4 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Эрсдэлүүд

Дотоод хяналтын тогтолцоо сулрах, авлага, өр төлбөрийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байх холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчигдөх

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэж заасныг мөрдөж ажиллах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	527,211,979.47	138,274,922.00
33	АВЛАГА	23,605,830.00	17,690,370.00
335	Бусад авлага	23,605,830.00	17,690,370.00
3351	Байгууллагаас авах авлага	10,806,830.00	4,891,370.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	12,799,000.00	12,799,000.00
34	УРЬДЧИЛГАА	336,357,840.00	59,587,500.00
34600	Урьдчилж гарсан зардал	336,357,840.00	59,587,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	167,248,309.47	60,997,052.00
354	Хангамжийн материал	167,248,309.47	60,997,052.00
35410	Бичиг хэргийн материал	1,140,000.00	
35420	Аж ахуйн материал	31,555,652.00	31,555,652.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,935,200.00	2,935,200.00
35440	Түлш, шатах тослох материал	8,238,367.47	
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал		
35470	Бусад хангамжийн материал	123,379,090.00	26,506,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,377,295,629.31	2,192,424,609.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,377,295,629.31	2,192,424,609.99
391	Газар		
392	Биет хөрөнгө	1,372,006,587.72	2,188,806,318.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	100,000,000.00	
39202	Хуримтлагдсан элэгдэл		
39203	Авто-тээврийн хэрэгсэл	410,523,127.00	447,373,127.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(154,306,011.92)	(244,131,162.61)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,950,749,062.61	3,317,579,662.61
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,359,139,983.46)	(1,686,136,777.02)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	596,276,286.95	549,776,286.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	(172,095,893.46)	(195,654,818.49)
393	Биет бус хөрөнгө	5,289,041.59	3,618,291.55
39301	Програм хангамж	21,515,000.00	21,515,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(16,225,958.41)	(17,896,708.45)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,904,507,608.78	2,330,699,531.99
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,660,170.00	147,512,858.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,660,170.00	147,512,858.00
413	Өглөг	5,660,170.00	147,512,858.00
4136	Бусад өглөг	5,660,170.00	147,512,858.00
41361	Байгууллагад төлөх өглөг	5,660,170.00	147,512,858.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,898,847,438.78	2,183,186,673.99
51	Засгийн газрын хувь оролцоо	1,898,847,438.78	2,183,186,673.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,135,349,477.27	1,135,349,477.27
51101	Өмч: - төрийн	1,135,349,477.27	1,135,349,477.27
512	Хуримтлагдсан үр дүн	763,497,961.51	1,047,837,196.72
51210	Өмнөх үеийн үр дүн	763,497,961.51	763,497,961.51
51220	Тайлант үеийн үр дүн		284,339,235.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,904,507,608.78	2,330,699,531.99

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	22616129237.54	23847254236.15
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	366392990.13	1472027974.25
120	Нийтлэг татварын бус орлого	366392990.13	1472027974.25
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого		
120003	Торгуулийн орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	366392990.13	1472027974.25
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12555468.00	5754100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	102265780.56	84658041.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	251571741.57	1381615833.25
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	22249736247.41	22375226261.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	20447160823.20	21197103227.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	20446650823.20	21196593227.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	510000.00	510000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1802575424.21	1178123034.90
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бүс этгээдээс авсан хандив, тусламж		
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	1137222914.21	900108677.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	665352510.00	210321000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		22500000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		45193357.40
131106	Төсвийн урамшуулал		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	22247745305.11	23441734500.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22247745305.11	23441734500.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21640164683.40	21537476998.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4541619230.18	4467674748.45
210101	Үндсэн цалин	4521619230.18	4336825076.35
210102	Нэмэгдэл		
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	20000000.00	130849672.10
210105	Гэрээт ажлын хөлс		
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	494899233.10	473520406.00
210201	Тэтгэврийн даатгал	436486834.33	400890070.00
210202	Тэтгэмжийн даатгал	7414948.60	7209378.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14579024.19	23158450.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7260376.60	14351512.00
210205	Эрүүл мэндийн даатгал	29158049.38	27910996.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2351848560.00	6125172447.00
210301	Гэрэл, цахилгаан	1000000000.00	2012273400.00
210302	Түлш, халаалт	1334208560.00	3321686778.00
210303	Цэвэр, бохир ус		737726600.00
210304	Байрны түрээс	17640000.00	53485669.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2797885060.23	1734513671.27
210401	Бичиг хэрэг	119364422.00	129433040.65
210402	Тээвэр, шатахуун	21155459.99	26392357.47
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21690780.24	30243943.15
210404	Ном, хэвлэл	2633012398.00	1541734118.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2662000.00	6710212.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10426300.00	3472200.00
210604	Урсгал засвар	10426300.00	3472200.00
2107	Томилолт, зочны зардал	1679485763.50	74202700.00
210701	Гадаад албан томилолт	12350597.50	
210702	Дотоод албан томилолт	1660083406.00	74202700.00

210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	7051760.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7936234514.25	7799522712.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7922293967.15	7781386932.81
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	2000000.00	1987680.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	861200.00	852000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	131000.00	100000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10948347.10	15196100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1827766022.14	859398112.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	956910799.00	360191347.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	548408644.00	42189813.30
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	322446579.14	457016952.33
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	607580621.71	1904257502.54
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3052500.00	4222144.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	3052500.00	4222144.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	409299903.00	1701641388.60
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	391829801.00	47371557.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		1565905798.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17470102.00	88364033.60
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	195228218.71	198393969.94
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	195228218.71	198393969.94
213304	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	368383932.43	405519735.45
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	368383932.43	405519735.45

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	22365252695.97	22465278612.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	115516448.56	90052351.00
120	Нийтлэг татварын бус орлого	115516448.56	90052351.00
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого		
120003	Торгуулийн орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	115516448.56	90052351.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12555468.00	5754100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	102960980.56	84298251.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	22249736247.41	22375226261.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	20447160823.20	21197103227.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	20446650823.20	21196593227.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	510000.00	510000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1802575424.21	1178123034.90
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	1137222914.21	900108677.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	665352510.00	210321000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		22500000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		45193357.40
131106	Төсвийн урамшуулал		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	22362182695.97	22458568012.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22362182695.97	22458568012.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21754602074.26	20554310510.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4541842085.41	4455735500.00
210101	Үндсэн цалин	4376754885.41	4139971700.00
210102	Нэмэгдэл		12101800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	145087200.00	156662000.00
210104	Урамшуулал	20000000.00	147000000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	494676377.86	473511400.00
210201	Тэтгэврийн даатгал	494676377.86	301419680.00
210202	Тэтгэмжийн даатгал		34053364.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		42556278.00
210204	Ажилгүйдлийн даатгал		10408959.00
210205	Эрүүл мэндийн даатгал		85073119.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2351848560.00	6125172447.00
210301	Гэрэл, цахилгаан	1000000000.00	2012273400.00
210302	Түлш, халаалт	1334208560.00	3321686778.00

210303	Цэвэр, бохир ус		737726600.00
210304	Байрны түрээс	17640000.00	53485669.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	2828581980.24	1619118937.80
210401	Бичиг хэрэг	118974882.00	17049090.65
210402	Тээвэр, шатахуун	25525620.00	17948490.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21690780.24	30243943.15
210404	Ном, хэвлэл	2659330698.00	1549038622.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3060000.00	4838792.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7996300.00	3472200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	7996300.00	3472200.00
2107	Томилолт, зочны зардал	1682469263.50	74202700.00
210701	Гадаад албан томилолт	12002597.50	
210702	Дотоод албан томилолт	1663414906.00	74202700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	7051760.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8339424564.25	7400436279.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8325484017.15	7382047499.26
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	2000000.00	1987680.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	861200.00	852000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	131000.00	100000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10948347.10	15449100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1507762943.00	402661046.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	959208799.00	360380147.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	548554144.00	42280899.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	607580621.71	1904257502.54
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3052500.00	4222144.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	3052500.00	4222144.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	409299903.00	1701641388.60
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	391829801.00	47371557.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		1565905798.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17470102.00	88364033.60
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	195228218.71	198393969.94
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	195228218.71	198393969.94
213304	Хөрөнгийн		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3070000.00</u>	<u>6710600.00</u>

	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3070000.00	6710600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3070000.00	6710600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3070000.00	6710600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3070000.00	6710600.00
2260	Гадаад эх үүсвэрээр	0.00	0.00
226001	Гадаад эх үүсвэрээр		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-3070000.00</u>	<u>-6710600.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>0.00</u>	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2015 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,135,349,477.27		25,201,671.86		1,160,551,149.13
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,135,349,477.27	0.00	25,201,671.86	0.00	1,160,551,149.13
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-8,392,562.23		-8,392,562.23
C08	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,135,349,477.27	0.00	763,497,961.51	0.00	1,898,847,438.78
D01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,135,349,477.27	0.00	763,497,961.51	0.00	1,898,847,438.78
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,135,349,477.27	0.00	763,497,961.51	0.00	1,898,847,438.78
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			284,339,235.21		284,339,235.21
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,135,349,477.27	0.00	1,047,837,196.72	0.00	2,183,186,673.99

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,494,314,300.00	20,539,062,461.76	22,002,021,600.00	21,287,155,578.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,494,314,300.00	20,539,062,461.76	22,002,021,600.00	21,287,155,578.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,976,410,000.00	19,967,131,837.16	20,293,778,100.00	19,462,032,957.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,570,743,500.00	4,541,842,085.41	4,438,455,500.00	4,438,455,500.00
210101	Үндсэн цалин	4,390,626,500.00	4,376,754,885.41	4,122,691,700.00	4,122,691,700.00
210102	Нэмэгдэл			12,101,800.00	12,101,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	150,117,000.00	145,087,200.00	156,662,000.00	156,662,000.00
210104	Урамшуулал	30,000,000.00	20,000,000.00	147,000,000.00	147,000,000.00
210105	Гэрээт ажлын хөлс				
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	502,781,700.00	494,676,377.86	471,610,600.00	471,610,600.00
210201	Тэтгэврийн даатгал	502,781,700.00	494,676,377.86	301,419,680.00	301,419,680.00
210202	Тэтгэмжийн даатгал			34,053,364.00	34,053,364.00
210203	ҮОМШӨ-ний даатгал			42,556,278.00	42,556,278.00
210204	Ажилгүйдлийн даатгал			8,508,159.00	8,508,159.00
210205	Эрүүл мэндийн даатгал			85,073,119.00	85,073,119.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,518,340,100.00	2,351,848,560.00	6,446,058,800.00	6,125,172,447.00
210301	Гэрэл, цахилгаан	1,344,041,700.00	1,000,000,000.00	1,879,093,600.00	2,012,273,400.00
210302	Түлш, халаалт	2,358,446,900.00	1,334,208,560.00	3,448,080,200.00	3,321,686,778.00
210303	Цэвэр, бохир ус	795,851,500.00		1,061,135,000.00	737,726,600.00
210304	Байрны түрээс	20,000,000.00	17,640,000.00	57,750,000.00	53,485,669.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,820,106,600.00	2,807,545,780.24	1,682,033,200.00	1,614,598,037.80
210401	Бичиг хэрэг	121,939,600.00	117,840,682.00	14,972,600.00	16,610,090.65
210402	Тээвэр, шатахуун	25,831,000.00	25,525,620.00	14,565,700.00	13,866,590.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	24,166,000.00	21,690,780.24	28,784,200.00	30,243,943.15
210404	Ном, хэвлэл	2,643,812,000.00	2,639,428,698.00	1,619,172,000.00	1,549,038,622.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал				
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,358,000.00	3,060,000.00	4,538,700.00	4,838,792.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал				
2105	Нормативт зардал	-	-	-	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл				
210502	Хоол, хүнс				
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл				
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,300,000.00	4,300,000.00	5,009,300.00	3,472,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл				
210602	Тавилга				
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл				
210604	Урсгал засвар	4,300,000.00	4,300,000.00	5,009,300.00	3,472,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,702,353,100.00	1,659,995,866.00	70,007,000.00	67,830,700.00
210701	Гадаад албан томилолт	5,229,400.00	2,243,500.00		
210702	Дотоод албан томилолт	1,672,318,400.00	1,650,700,606.00	70,007,000.00	67,830,700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	24,805,300.00	7,051,760.00		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,546,668,900.00	7,812,613,878.65	7,016,540,500.00	6,582,494,272.76
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,525,047,400.00	7,798,288,331.55	6,995,587,000.00	6,564,105,492.76
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох				
210803	Даатгалын үйлчилгээ	2,000,000.00	2,000,000.00	2,000,000.00	1,987,680.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,000,000.00	861,200.00	2,000,000.00	852,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	900,000.00	131,000.00	100,000.00	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,221,500.00	11,333,347.10	16,853,500.00	15,449,100.00
210807	Газрын төлбөр	1,500,000.00			
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж				
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх				
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	311,116,100.00	294,309,289.00	164,063,200.00	158,399,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	311,116,100.00	294,309,289.00	156,733,000.00	151,733,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх			7,330,200.00	6,666,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	517,904,300.00	571,930,624.60	1,708,243,500.00	1,825,122,620.44
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	15,000,000.00	3,052,500.00	5,000,000.00	4,222,144.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг				
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	15,000,000.00	3,052,500.00	5,000,000.00	4,222,144.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	502,904,300.00	400,675,192.00	1,703,243,500.00	1,679,141,388.60
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж				
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж				
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	424,739,100.00	383,205,090.00	28,198,200.00	24,871,557.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал			1,566,377,300.00	1,565,905,798.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт				
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	78,165,200.00	17,470,102.00	108,668,000.00	88,364,033.60
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг				

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал				
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		168,202,932.60	-	141,759,087.84
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		168,202,932.60		141,759,087.84
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23,494,314,300.00	20,539,062,461.76	22,002,021,600.00	21,287,155,578.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,315,896,800.00	20,447,160,823.20	21,952,021,600.00	21,197,103,227.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	23,315,896,800.00	20,446,650,823.20	21,952,021,600.00	21,196,593,227.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих				
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих				
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих				
130305	Нэр данс зөрүүтэй орсон орлого		510,000.00		510,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	178,417,500.00	91,901,638.56	50,000,000.00	90,052,351.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	97,000,000.00	12,555,468.00		5,754,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	81,417,500.00	79,346,170.56	50,000,000.00	84,298,251.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих				
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
610001	Төсвийн байгууллага				
610002	Төсвөөс гадуур байгууллага				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	95.00	95.00	106.00	106.00
620001	Удирдах ажилтан	15.00	15.00	11.00	11.00
620002	Гүйцэтгэх ажилтан	80.00	80.00	95.00	95.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	95.00	95.00	106.00	106.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	87.00	87.00	96.00	96.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)				
650003	Ажлын албаны албан хаагч (АА)			2.00	2.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	8.00	8.00	8.00
650010	Гэрээт ажилтан				
650011	Улс төрийн албан хаагч (УТ)				